



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ТАТВАРЫН ОРЛОГО НЭР ТӨРЛӨӨР БҮРЭН ТӨВЛӨРӨХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛИЙГ ТООЦОХГҮЙГЭЭР САНГИЙН ЯАМНААС ХЯНАЖ, УИХ-ААС БАТАЛСАН СУУРЬ ЗАРЛАГА ДЭЭР ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫГ 2,157.6 СЯА ТӨГРӨГӨӨР, АЙМГИЙН 2026 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ 2,037.9 СЯА ТӨГРӨГӨӨР ТУС ТУС НЭМЭГДҮҮЛЖ ТӨЛӨВЛӨСӨН НЬ ТӨСВИЙН ҮР АШГИЙГ БУУРУУЛЖ БАТЛАХ ЭРСДЭЛИЙГ ДАГУУЛЖ БАЙНА.

АУДИТЫН КОД: ЗАА-2025/07-12-ШТА-НА



Улиастай хот
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: boldbaatar@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Оюунсүвд
Утас: 99076038, Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Аудитор Г.Баасанжаргал
Утас: 99032514, Цахим хаяг: baasanjargalq@audit.gov.mn

Аудитор Т.Баасанжаргал
Утас: 92012266, Цахим хаяг: baasanjargalt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.open.audit.mn

АГУУЛГА

Тушаал 2
Товчилсон үгийн тайлбар 3
Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёг3-4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, аудитын шалгуур үзүүлэлт, ерөнхий мэдээлэл.....5-7

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 2,478.0 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

1.1. Орон нутгийн татварын орлогыг 8 нэр төрөлд 1,978.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна7-16
1.2. Татварын бус орлогыг 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна16-18

БҮЛЭГ 2. ЗАВХАН АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД УРСГАЛ ЗАРДЛЫГ 1,786.6 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ, ТӨСВИЙН ҮР АШГИЙГ 1,328.0 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

2.1 Орон нутгийн 2026 оны төсвийн урсгал зардлыг 1,786.6 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.....19-25
2.2 Орон нутгийн төсвийн үр ашгийг 1,328.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.....25-28

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХУУЛЬ, ЖУРМЫН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ, ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХГҮЙ 9 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД НИЙТ 1,290.5 САЯ ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

3.1. Орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөж, хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй 635.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, хууль, журмын чиг үүрэгт хамаарахгүй 655.5 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.....28-33

ДҮГНЭЛТ34

ЗӨВЛӨМЖ35



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 1140

Улиастай

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд
дүгнэлт өгөх аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх” -ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитаар өгсөн зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу төлөвлөгөө гарган ирүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

3.Аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэхийг аудитор (Г.Баасанжаргал)-д, цахим хуудсаар нийтэд мэдээлэхийг аудитор (Г.Нармандах)-д үүрэг болгосугай.

4.Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Ц.Оюунсүвд)-д даалгасугай

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.



Д.БАТ-УНДРАА

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНЗС	Орон нутгийн замын сан
БХНСАХЗ	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл

Хүснэгтийн товьёг

Хүснэгт-1	Нэгдсэн төсвийн гүйцэтгэл 2022-2024 он
Хүснэгт-2	Аймгийн 2026 оны төсвийн суурь орлого 2022-2024 он
Хүснэгт-3	Малын тооллого
Хүснэгт-4	Малын тоо толгойн албан татвар
Хүснэгт-5	Галт зэвсгийн албан татварын судалгаа
Хүснэгт-6	Хог хаягдлын хураамжийн судалгаа
Хүснэгт-7	Төсвийн орлого нэмэгдүүлэх саналын нэгтгэл
Хүснэгт-8	Орон нутгийн 2026 оны төсвийн зардал /сая.төгрөг/
Хүснэгт-9	Аймгийн Засаг дарга дансанд зориулалт бусаар төлөвлөсөн арга хэмжээний жагсаалт
Хүснэгт-10	Орон нутгийн 2026 оны төсвийн зардлын ангилал
Хүснэгт-11	Орон нутгийн 2026 оны төсвийн зардлыг байгууллагад хуваарилсан байдал
Хүснэгт-12	Орон нутгийн төсвийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл
Хүснэгт-13	Төсвийн урсгал зардал бууруулах санал
Хүснэгт-14	Төсөл арга хэмжээ
Хүснэгт-15	Их засварын зардлын төлөвлөлт
Хүснэгт-16	Орон нутгийн авто замын сангийн төлөвлөлт
Хүснэгт-17	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөлт
Хүснэгт-18	Их засварын зардлаас зориулалт бус төлөвлөлт
Хүснэгт-19	Орон нутгийн авто замын сангийн төлөвлөлт
Хүснэгт-20	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ
Хүснэгт-21	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээний жагсаалт
Хүснэгт-22	Зориулалт бус төсөл арга хэмжээний төлөвлөлт
Хүснэгт-23	Төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх саналын нэгтгэл

Дүрслэлийн товъёг

График-1	<i>Малын тоо толгойн албан татвар</i>
График-2	<i>Тээврийн хэрэгслийн албан татварын хэрэгжилт</i>
График-3	<i>Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын судалгаа</i>
График-4	<i>Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын судалгаа</i>
График-5	<i>Хог хаягдлын хураамжийн судалгаа</i>
График-6	<i>Газрын төлбөр</i>
График-7	<i>Улсын тэмдэгтийн хураамж</i>
График-8	<i>Хүү, торгуулийн орлого</i>
График-9	<i>Дуудлага худалдааны орлогын гүйцэтгэл</i>

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” 2025 оны А/08, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.5.1 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт өгөх аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт өгч, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтыг хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: <ul style="list-style-type: none">- Төсвийн төсөлд орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх боломжийг тусгасан эсэх;- Төсвийн төсөлд зардал бууруулах болон төсвийн санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг тусгасан эсэх;- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль журмын шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, аймгийн Татварын газар, холбогдох бусад төсөвт байгууллагууд болон ТЭЗ-ийн 2026 оны нэгтгэсэн төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, 2026 оны орон нутгийн татварын орлогын Сангийн яамны хянасан төлөвлөгөө, 2025 оны төсвийн зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэл зэргийг хамрууллаа.
Талуудын хүлээх үүрэг, хариуцлага	Аймгийн Засаг дарга нь төсвийн төслийг холбогдох шаардлагад нийцүүлэн нэгтгэн боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасны дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлэх үүрэгтэй.
Аудитын арга зүй	Орон нутгийн төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм. Аудитыг АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалт хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тайлбар

Шалгуур үзүүлэлт

тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлэн, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан, зөвлөмж бэлтгэлээ.

Завхан аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн орон нутгийн 2026 оны төсвийн төсөл нь төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам заавар, аргачлал, түүний дотор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор батлагдсан "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам", Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам", Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", Сангийн сайдын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-д нийцсэн эсэхийг шалгуур үзүүлэлтээр авч үзлээ.

**Аудитын багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, аудитын менежер Х.Болдбаатар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитор Г.Баасанжаргал, Т.Баасанжаргал нар гүйцэтгэлээ.

Аудитыг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлж, хөтөлбөрт заасан хугацаанд холбогдох үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын тайлан, дүгнэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Завхан аймгийн Засаг даргаас 2026 оны орон нутгийн төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн хязгаараас урсгал зардлыг 30,909.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зарлагыг 95,413.4 сая төгрөгөөр төлөвлөж, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 68,541.2 сая төгрөгөөр, орон нутгийн татварын болон татварын бус орлогоос 26,872.2 сая төгрөгөөр төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулиар Завхан аймгийн 2026 оны төсвийн нийт зарлагыг 67,297.3 сая төгрөгөөр баталснаас, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 36,008.3 сая төгрөг, орон нутгийн татварын болон татварын бус орлогоос 31,289.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Завхан аймгийн 2026 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан төсөвлөлтөөр, Сангийн яамнаас ирүүлсэн "Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл"-ийг баримтлан төлөвлөж, Завхан

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 11 сарын 19-ний өдрийн 08/1097 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ:

Завхан аймгийн 2022-2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №1 Нэгдсэн төсвийн гүйцэтгэл 2022-2024 он /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт		2022	2023	2024
Орон нутгийн орлого	Төлөвлөгөө	41,223.50	55,312.80	76,906.80
	Гүйцэтгэл	44,787.60	60,958.00	85,163.30
	Биелэлт	108.65	110.21	110.74
Санхүүгийн дэмжлэг	Гүйцэтгэл	14,834.70	23,254.70	37,893.30
Баталсан төсөв, зарлага	Төлөвлөгөө	52,346.90	67,698.90	93,135.80
	Гүйцэтгэл	44,364.30	61,600.10	85,842.20
	Биелэлт	84.75	90.99	92.17

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 2,478.0 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

1.1. Орон нутгийн татварын орлогыг 8 нэр төрөлд 1,978.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

1.1.1. Орон нутгийн татварын орлогыг 8 нэр төрөлд 1,978.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.

Аймгийн 2026 оны төсвийн суурь орлогыг 26,872.2 сая төгрөгөөр төлөвлөн Сангийн яаманд хүргүүлж, 31,289.0 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

Сангийн яамнаас орон нутгийн татварын суурь орлогыг өмнөх оноос 25.9 хувиар буюу 2,417.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж хянасан байна. Татварын орлого 29,699.6 сая төгрөг буюу 94.9 хувийг, татварын бус орлогыг 1,589.4 сая төгрөг буюу 5.1 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт №2 Аймгийн 2026 оны төсвийн суурь орлого 2022-2024 он /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Сангийн яамнаас хянасан 2026 оны суурь орлого	2026 оны төсвийн төсөл	Зөрүү	Өөрчлөлтийн хувь
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	67,297.3	71,492.8	4,195.5	6.2
Татварын орлого	31,289.0	33,789.0	2,500.0	8.0
Орлогын албан татвар	25,886.8	28,386.8	2,500.0	9.7
Хөрөнгийн албан татвар	1,434.0	1,434.0	0.0	-
Бусад татвар, төлбөр, хураамж	2,378.8	2,378.8	0.0	-
Татварын бус орлого	1,589.4	1,589.4	0.0	-
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	36,008.3	36,008.3	0.0	-
Харилцах дансны урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.0	1,695.5	1,695.5	-

Эх сурвалж: Завхан аймгийн 2026 оны төсвийн төсөл

Орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл 2025 оны 10 сарын 31-ний байдлаар 7,466.3 сая төгрөг буюу 21 хувиар тасарсан үзүүлэлттэй, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 390.6 сая төгрөг буюу 1.1 хувиар давж биелүүлэхээр тооцоолсон байна.

Орон нутгийн төсвийн орлогыг аймгийн Татварын газраас ирүүлсэн мэдээнд үндэслэн төсвийн шатлалаар авч үзвэл:

Аймгийн татварын орлогоор 2025 онд 4,151.9 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, 2025 оны 10 сарын 31-ний байдлаар 159.1 сая төгрөг буюу 3.8 хувиар давж биелсэн байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 417.7 сая төгрөг 10.1 хувиар давж биелүүлэхээр тооцоолсон байна.

Харин Сумдын татварын орлогоор 2025 онд 31,490.1 сая төгрөг бүрдүүлэхээр төлөвлөж, 2025 оны 10 сарын 31-ний байдлаар 7,625.4 сая төгрөг буюу 24.2 хувиар тасарсан үзүүлэлттэй байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 27.1 сая төгрөг буюу 0.1 хувиар тасарна гэж тооцоолсон байна.

Төсвийн орлогын гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр судалж үзэхэд сумдад төвлөрөх татварын орлого ахуйн хэрэглээний ус, рашаан ашигласны төлбөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны нөөц ашигласны төлбөр, хөрөнгийн орлого /хүүгийн орлого/, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар зэрэг 5 нэр төрлийн орлого тасрах эрсдэлтэй байна.

Аудитаар орон нутгийн татварын орлогыг 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөө, хүлээгдэж буй гүйцэтгэл болон 2026 оны Сангийн яамны хянасан суурь орлоготой харьцуулан тооцоолоход дараах нэр, төрлийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна. Үүнд:

Малын тоо толгойн албан татвар: Тус татварын хувь хэмжээг тогтоосон сумдын ИТХ-ын тогтоол, аймгийн Статистикийн хэлтсээс 2024 оны жилийн эцэст тоологдсон малын тоо, 2025 оны эхний хагас жилийн байдлаар хорогдсон болон бойжсон төлийн тоо мэдээг сумдаар авч, сумдын татварын орлогын 2025 оны 10 сарын 31-ний өдрөөрх малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мөнгөн дүнтэй уялдуулан тооцоолол хийлээ.


Хүснэгт №3 Малын тооллого

2024 оны тоологдсон	2025 оны эхний хагас хорогдсон	2026 оны эхний хагас бойжсон төл	Нийт малын тоо 2025 оны эхний хагас
3,008,248	7,642	1,001,444	4,002,050

Завхан аймгийн хэмжээнд 2025 оны 6 сарын байдлаар нийт 4,002,050 толгой мал тоологдсон байна. Тооцооллыг сумдын ИТХ-ын тогтоосон хувь хэмжээгээр 2024 оны эцэст тоологдсон малын тоо толгойгоор тооцоход 1,228.5 сая төгрөгийн албан татвар ногдуулбал зохих тооцоолол гарч байна.

Аймгийн Татварын газраас ирүүлсэн судалгаагаар 2025 онд 585.7 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас 2025 оны 10 сарын гүйцэтгэлээр 511.5 сая төгрөг, ХБГ-ээр 763.6 сая төгрөг төвлөрөх тооцоолол ирүүлсэн байна.

График 1. Малын тоо толгойн албан татвар



Сумдын 2024, 2025 оны төлөвлөгөөг харьцуулахад 14.4 хувиар буурсан нь Алдархаан, Асгат, Баянхайрхан, Их-Уул, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй сумд орлого төлөвлөөгүй байна. Иймд сүүлийн 3 жилийн сумдын малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөний дундаж дүнгийн 40 хувиар ногдуулан, 2025 оны 10 сарын 31-ний өдрөөрх гүйцэтгэлтэй харьцуулан 2026 оны малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг **678.0** сая төгрөгөөр төлөвлөх боломжтой байна.


Малын тоо толгойн албан татварын сүүлийн 3 жилийн дунджийг харьцуулан гаргасан 2026 оны төлөвлөгөөний санал:

Хүснэгт №4 Малын тоо толгойн албан татвар /2022-2024/

Сумдын нэр	2023 оны төлөвлөгөө	2024 оны төлөвлөгөө	2025 оны жилийн төлөвлөгөө	2026 оны жилийн төлөвлөгөө санал /сая.төг/
Алдархаан	50.0	22.6	-	29.0
Асгат	7.0	9.0	-	6.4
Баянтэс	30.0	50.0	20.0	34.7
Баянхайрхан	53.0	22.6	-	30.2
Дөрвөлжин	33.0	19.7	29.7	25.0
Завханмандал	20.0	40.0	32.0	28.3
Идэр	24.0	58.3	50.1	39.6
Их-Уул	55.0	32.4	-	35.0
Нөмрөг	30.0	17.7	27.7	22.8
Отгон	85.0	40.0	45.0	56.0
Сантмаргац	28.0	17.0	27.0	21.6
Сонгино	65.0	12.0	22.0	33.7
Тосонцэнгэл	65.0	64.0	20.0	54.3
Түдэвтэй	60.0	41.4	51.4	47.4
Тэлмэн	48.0	33.1	43.1	38.2
Тэс	20.0	18.0	28.0	18.9
Улиастай	15.0	15.0	15.0	14.0
Ургамал	22.4	76.3	50.0	46.1
Цагаанхайрхан	15.0	14.0	78.9	22.1
Цагаанчулуут	12.0	12.0	-	9.6
Цэцэн-Уул	26.0	15.3	-	16.5
Шилүүстэй	16.0	14.0	-	12.0
Эрдэнэхайрхан	36.0	21.2	22.2	25.9
Яруу	-	18.6	23.6	10.6
Нийт	815.4	684.3	585.7	678.0

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар: Тус албан татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулахад дараах байдалтай байна.

График 2. Тээврийн хэрэгслийн албан татварын хэрэгжилт



Сангийн яамны 2026 оны хянасан төлөвлөгөөгөөр суурийг 518.0 саяар баталсан нь өмнөх оны төлөвлөгөөнөөс 71.2 сая төгрөгөөр буюу 12 хувиар бууруулж баталсан байна. Аймагт 2023 онд 17638, 2024 онд 19281, 2025 онд 21962 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Жилээс жилд авто тээврийн хэрэгсэл нэмэгдэж байгаатай холбоотой 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй уялдуулан 64.0 сая төгрөгийн 50 хувиар буюу **32.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого: Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөө, 2025 оны 10 сарын 31-ний байдлаарх гүйцэтгэл, хүлээгдэж буй гүйцэтгэлийг графикаар харуулахад дараах байдалтай байна.

График 3. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын судалгаа



ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

Тус орлогын гүйцэтгэл 2023 онд 3,854.4 сая төгрөг, 2024 онд 1,833.3 сая төгрөгөөр давж биелсэн бол 2025 оны 10 сарын 31-ний байдлаарх орлогын гүйцэтгэл 72.5 хувьтай байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 20,654.6 сая төгрөг төвлөрүүлж, тус орлогыг 1,460.0 сая төгрөгөөр тасарна гэж тооцоолсон байна.

2026 оны төсвийн төсөлд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 19,600.0 сая төгрөгөөр санал хүргүүлж, Сангийн яам 2,680.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 22,000.0 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны батлагдсан төсвийг 114.7 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд заасан зорилтыг үндэслэн багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувь бууруулах арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлсэн. 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тооцож Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Мөн “2026 онд багш, эмч нарын цалинг 30-70 хүртэл хувиар үе шаттайгаар өсгөж үндсэн цалинг 3.5 сая төгрөг болгож нэмэгдүүлэх тухай Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Үйлдвэрчний эвлэлийн холбоод “2024-2026 онд байгуулсан хамтын хэлэлцээрийн нэмэлт хэлэлцээр” байгуулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн боловч эцсийн шийдвэр гараагүй байна. Багш нарын цалин нэмэгдэх боломжтой тул 751.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналтай байна.

Тосонцэнгэл суманд “Дулааны цахилгаан станц” шинээр байгуулагдаж, 2024 онд 14 албан хаагчид 279.6 сая төгрөг, 2025 оны 01-11 сар хүртэл 30 албан хаагчид 677.2 сая төгрөгийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого тооцож олгосон бөгөөд 2026 онд урьдчилсан тооцооллоор 45 албан хаагчид 1,015.5 сая төгрөгийн цалин хөлс олгохоор тооцсон нь төсвийн орлого 89.8 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна.

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг нийт **841.6** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна гэж үзлээ.

Галт зэвсгийн албан татвар: Завхан аймаг дахь Цагдаагийн газраас 24 сумын галт зэвсэг эзэмшиж байгаа, иргэн аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг 2025 оны 11 сарын 20-ны өдрийн байдлаар авахад бүртгэлтэй 2802 ширхэг галт зэвсэг байна. Үүнээс: ан агнуурын зориулалтын 2769, спорт-сургалтын 25, харуул хамгаалалтын 6, цуглуулга 2 галт зэвсэг байна. Ан агнуурын зориулалттай буюу 6.4 мм хүртэлх калибрын бүх төрлийн галт зэвсэг $2769 \times 30.0 = 83.1$ сая төгрөгийн татварын орлого бүрдэх боломжтой байна.

2021-2024 оны галт зэвсгийн албан татварын орлогын судалгааг хийхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №5 Галт зэвсгийн албан татварын судалгаа

Он	Татварын орлогын төлөвлөгөө	Татварын орлогын гүйцэтгэл	Хувь	Давсан, тасарсан үзүүлэлт /сая.төг/
2021	67.00	63.04	94.1	(3.96)
2022	70.00	52.42	74.9	(17.58)
2023	60.00	54.77	91.3	(5.23)
2024	54.00	65.37	121.1	11.37
2025 ХБГ	56.00	57.86	103.3	1.86

Дээрх хүснэгтээс харахад 2021-2023 онд төлөвлөгөө өсөхөд тасарсан, 2024 онд төлөвлөгөө буурахад 21.1 хувиар давсан харагдаж байна.

Аймгийн Татварын газар болон цагдаагийн газрын хамтын ажиллагааг сайжруулж галт зэвсэг эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжийн татварыг төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

Дээрх тооцоололд 0.7 сая төгрөгийн өрийг тооцоолоогүй бөгөөд өрнөөс гадна төвлөрүүлэх ёстой орлогоо бүрэн төвлөрүүлнэ гэж үзвэл тооцоолсон боломжоос 2026 оны сангийн яамны хянасан 56.0 сая төгрөгийг хасаж, 27.1 сая төгрөгийн 30 хувиар тооцоолж, **8.1** сая төгрөгийг нэмэгдүүлэх боломжтой байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар: Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөө, 2025 оны 10 сарын 31-ний байдлаарх гүйцэтгэл болон хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026 оны төсвийн төсөлд өгсөн орлогын санал, Сангийн яамнаас баталсан орлогын төлөвлөгөөг графикаар харуулахад дараах байдалтай байна.

График 4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын судалгаа




Орлогын гүйцэтгэл 2023 онд 470.6 сая төгрөг, 2024 онд 437.9 сая төгрөгөөр давж биелсэн, 2025 оны 10 сарын 31-ний байдлаарх орлогын гүйцэтгэл 58.4 хувьтай, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,238.2 сая төгрөгөөр биелүүлж, эхээр тооцоолсон байна. 2025 онд 21.9 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогыг 2026 оны төсвийн төсөлд 994.4 сая төгрөгөөр санал өгснийг Сангийн яам 134.4 сая төгрөгөөр бууруулж, 860.0 сая төгрөгөөр баталсан байна. 2023, 2024 оны давсан орлогын дундаж өсөлт 1,045.6 сая төгрөг бөгөөд 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл нь өмнөх оны давсан орлогоос 12 хувиар өсөхөөр тооцож байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогыг өмнөх онуудын давсан орлогын дундаж өсөлт, төлөвлөгөөтэй уялдуулж **134.3** сая төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн саналыг бууруулахгүй 994.4 сая төгрөгөөр төлөвлөх саналтай байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамж: Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөө, 10 сарын 31-ний байдлаарх гүйцэтгэл болон хүлээгдэж буй гүйцэтгэлийг графикаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

График 5. Хог хаягдлын хураамжийн судалгаа



2023 онд хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 150.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 43.2 сая төгрөгөөр буюу 28.8 хувиар, 2024 онд 184.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 67.3 сая төгрөгөөр буюу 36.5 хувиар тасарсан бөгөөд 2025 онд 128.0 сая төгрөгөөр төлөвлөж, 2025 оны 10 сарын 31-ний байдлаар 59.2 сая төгрөгөөр буюу 46.2 хувиар тасарсан боловч хүлээгдэж буй гүйцэтгэлээр 10 хувиар давж биелүүлэхээр тооцоолсон байна. Дөрвөлжин, Их-Уул, Отгон, Түдэвтэй сумд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 2025 оны 10 сарын 31-ний байдлаар 50-316.6 хувиар давуулан биелүүлсэн, Тэлмэн, Цагаанхайрхан, Цагаанчулуут сумд 90-ээс дээш хувиар биелүүлсэн бол бусад сумдад хог хаягдлын үйлчилгээний хураамж тасарсан байна. Сангийн яамны 2026 оны хянасан төлөвлөгөөгөөр хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын суурийг өмнөх оноос 23.0 сая төгрөгөөр буюу 18 хувиар бууруулж, 105.0 сая төгрөгөөр баталсан байна.

Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Хог хаягдлын талаар аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 9.1.1-д “нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих”, 9.1.2-д “хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавих”, 9.1.3-д “энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх”, 9.2-д “Хог хаягдлын талаар сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөл энэ хуулийн 9.1.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 9.2.1-д “энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг батлах”, 9.3-д “Хог хаягдлын талаар аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 9.3.1-д “хог хаягдлын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах”, 9.3.4-д “хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийн биелэлтийг хангах”, 9.3.6-д “хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтыг нутаг дэвсгэрийн хэмжээнд

зохион байгуулах”, 9.4-д “Хог хаягдлын талаар сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 9.4.1-д “нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх”, 9.4.8-д “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих”, 9.5-д “Хог хаягдлын талаар баг, хорооны Засаг дарга, тосгоны Захирагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 9.5.1-д “нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх”, 9.5.3-д “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих” гэж шат, шатны ИТХ болон шат, шатны Засаг даргын эрх, үүргийг хуульчилсан байна. Гэвч шат, шатны Засаг дарга нар Хог хаягдлын тухай хууль болон сумын ИТХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтнууд хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлж ажиллаагүйгээс хуулийн хэрэгжилт хангагдахгүй, хог хаягдлын үйлчилгээний хураамж бүрэн төвлөрөхгүй, тасарч байна.

Мөн Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д “Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах үүрэг хүлээнэ”, 10.2.7-д “хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх”, 41 дүгээр зүйлийн 41.1-д “Энгийн хог хаягдал үүсгэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүр хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө.”, 41.7-д “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эрчим хүч, хэрэглээний цэвэр, бохир ус, дулаан, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж болно.”, 41.12-д “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих, бүх нийтийн их цэвэрлэгээ, сургалт, сурталчилгаа зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын төсөвт тусгаж зарцуулна.” гэж заасан бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдлын үйлчилгээний хураамжийг жил бүр ногдуулдаггүй, өр, авлагын тооцоо үүсгэдэггүйгээс, тус орлого бүрэн төвлөрөхгүй, тасарч байна гэж дүгнэлээ.

Суманд төвлөрөх хог хаягдлын хураамжийг тооцвол суурин болон малчин өрх, ААНБ-аар тооцоолоход дараах байдалтай байна.

Хүснэгт №6 Хог хаягдлын хураамжийн судалгаа

№	ХУРААМЖ НОГДУУЛАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ	ТООЦООЛСОН МӨНГӨН ДҮН
1	Суурин өрхөөр	421.6
2	Малчин өрхөөр	66.1
3	ААНБ	87.7
	Нийт дүн	575.4

Сумдад төвлөрөх хог хаягдлын хураамжийг сумдын ИТХ-аас үйлчилгээний төрөл, чиглэлүүдээр тогтоосон үнэ тарифаар тооцоолоход айл өрхүүдээс 487.7 сая төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагаас 87.4 сая төгрөг тус тус төвлөрөх боломжтой байна. Орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх саналд Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2025 онд тооцоолсон орлогын 40 хувийг төвлөрүүлнэ гэж үзэхэд 230.0 сая төгрөг төвлөрөх бүрэн боломжтой бөгөөд Сангийн яамнаас хянасан төлөвлөгөө 105.0 сая төгрөгийг хасахад тус хураамжийг **125.0** сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна гэж үзлээ. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг иргэн, аж ахуйн нэгж,

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

байгууллагад ногдуулалтыг жил бүр хийж, 41.7-д заасны дагуу “эрчим хүч болон дулааны төлбөртэй хамтатган хураах” замаар төвлөрүүлж, тус орлогыг бүрдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах бүрэн боломжтой байна.

Газрын төлбөр: Газрын төлбөрийн 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөө, 10 сарын 31-ээр гүйцэтгэл, хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026 оны төсвийн төсөлд өгсөн орлогын санал, Сангийн яамнаас баталсан орлогын төлөвлөгөөг графикаар харуулахад дараах байдалтай байна.

График 6. Газрын төлбөрийн судалгаа



Газрын төлбөрийн орлогын гүйцэтгэл 2023 онд 402.2 сая төгрөг, 2024 онд 363.1 сая төгрөгөөр давж биелсэн бөгөөд 2025 оны 10 сарын 31-ний байдлаар 70 хувийн гүйцэтгэлтэй, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,117.1 сая төгрөг, өрийн үлдэгдэл 405.6 сая төгрөг байна. Газрын төлбөрийг 2026 онд 980.0 сая төгрөгөөр төсвийн төсөлд санал өгснийг Сангийн яам 175.0 сая төгрөгөөр бууруулж 805.0 төгрөгөөр баталсан байна. Мөн 2023, 2024 оны давсан орлогын дундаж 383.1 сая төгрөг байна. Газрын төлбөрийн орлогыг 2025 оны төлөвлөгөө, хүлээгдэж буй гүйцэтгэл, сүүлийн 2 жилийн давсан орлогын дундажтай уялдуулж тооцоход **125.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Улсын тэмдэгтийн хураамж: Улсын тэмдэгтийн хураамжийн 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөө, 2025 оны 10 сарын 31-ний байдлаарх гүйцэтгэл, хүлээгдэж буй гүйцэтгэлийг графикаар харуулахад дараах байдалтай байна.

График 7. Улсын тэмдэгтийн хураамжийн судалгаа



Улсын тэмдэгтийн хураамжийн орлогын гүйцэтгэл 2023 онд 54.1 сая төгрөг, 2024 онд 216.3 сая төгрөг, 2025 оны 10 сарын 31-ний байдлаар 7.7 сая төгрөгөөр давж биелсэн, хүлээгдэж буй гүйцэтгэл 373.5 сая төгрөг байна. Сүүлийн 3 жилийн байдлаарх давсан орлого тогтмол 324.0 сая төгрөгөөс дээш гүйцэтгэлтэй байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 2026 оны төсвийн төсөлд 296.0 сая төгрөгөөр санал өгснийг Сангийн яам 96.0 сая төгрөгөөр бууруулж, 290.0 сая төгрөгөөр баталсан байна.


Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг өмнөх онуудын давсан орлогын дундаж болон 2026 оны төлөвлөгөөтэй уялдуулан тооцоолж, 34.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна гэж үзлээ.

1.2. Татварын бус орлогыг 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

1.2.1. Татварын бус хүү, торгуулийн орлогыг 300.0 сая төгрөгөөр, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дуудлага худалдааны орлогыг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Хүү, торгуулийн орлого: Хүү торгуулийн орлогын 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөө, 2025 оны 10 сарын 31-ний байдлаарх хүлээгдэж буй гүйцэтгэлийг графикаар харуулахад дараах байдалтай байна.

График 8. Хүү торгуулийн орлогын судалгаа



Хүү, торгуулийн орлого нь Цагдаагийн газрын замын цагдаа, татварын хяналт шалгалтын торгуулийн орлого, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Улсын бүртгэлийн хэлтэс, бусад Улсын байцаагч нарын торгуулийн орлого, бусад нэр заагдаагүй орлого буюу актын төлбөрүүд (*төрийн аудитын газар, санхүүгийн хяналт, дотоод аудитын алба*), ой модтой сумдад торгуулийн орлогоос бүрдэж байна.

Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулахад 2023 онд 1,480.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 874.2 сая төгрөгөөр буюу 59 хувиар, 2024 онд 1,164.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 503.7 сая төгрөгөөр буюу 43.2 хувиар давж байсан бол 2025 онд аймагт 936.8 сая төгрөгөөр, сумдад 668.0 сая төгрөгөөр төлөвлөж, 2025 оны 10 сарын 31-ний байдлаар аймагт төвлөрөх хүү, торгуулийн орлогын гүйцэтгэл 30.3 хувь буюу 283.8 сая төгрөгөөр, сумдад төвлөрөх хүү, торгуулийн орлогын гүйцэтгэл 18.4 хувь буюу 122.9 сая төгрөгөөр давсан байна. Тус орлого хүлээгдэж буй гүйцэтгэлээр 55.1 сая

төгрөгөөр буюу 34.8 хувиар давж биелэх тооцоололтой байна. 2025 онд ногдуулсан 390.3 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байна.

Сангийн яамны 2026 оны хянасан төлөвлөгөөгөөр хүү, торгуулийн орлогын суурийг өмнөх оноос 15.4 сая төгрөгөөр бууруулж, 1,589.4 сая төгрөгөөр баталжээ. Хүү, торгуулийн орлого сүүлийн 3 жил 25.3-59 хувиар давж биелсэн байна. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар 2025 онд “Хүү, торгуулийн орлогын 2023-2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт” сэдэвт нийцлийн аудитыг хийсэн бөгөөд аудитаар “хүү торгуулийн орлогын 50.1-53.2 хувийг аймгийн Цагдаагийн газрын торгуулийн орлого эзэлж байна” гэж дүгнэжээ. Зөрчлийн тухай хуулиар 237 төрлийн торгох заалттай бөгөөд аймагт нийт зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 17 байгууллагын 106 албан тушаалтан байгаа ч аудитын дүгнэлтээр 10 байгууллагын 72 албан тушаалтан аудитын хамрах хугацаанд торгууль ногдуулаагүй, зарим нь торгууль ногдуулахгүйгээр зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгсөн ч биелэлтийг бодитой тооцож баримтжуулаагүй, албан шаардлага хэрэгжүүлээгүй байхад дараагийн шатны арга хэмжээ авч ажиллаагүй байна, мөн торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нийцэж, хуулийн хэрэглээ бүх нийтэд адил тэгш үйлчилж байна, эрх бүхий албан тушаалтнууд ногдуулсан торгуулийн хэрэгжилтэд анхаарч ажиллаагүйгээс тайлант хугацаанд 383.6 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна, хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлтэд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүү алба хяналт тавих чиг үүрэгтэй боловч торгуулийн орлогын бүрдүүлэлтийг зөвхөн төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлээр тайлагнаж байна. Аймгийн хэмжээнд торгууль ногдуулалт, хугацаа хэтрэлт, төлөлтийн явцад хяналт тавих нэгдсэн тогтолцоо бүрдээгүй, хяналт сүл байна, орлого бүрдүүлэгч байгууллагуудын удирдлага эрх бүхий албан тушаалтнуудад шийтгэлийн хуудсыг бүртгэлээр олгож, зарцуулалтыг хянаж байгаа ч торгуулийн орлогын биелэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байна” гэж дүгнэжээ. Аудитын дүгнэлт болон тус орлогын 2025 оны 10 сарын 31-ний байдлаарх гүйцэтгэлд үндэслэн, өмнөх оны өрийг тооцохгүйгээр хүү, торгуулийн орлогыг аймагт 207.0 сая төгрөг, сумдад 93.0 сая төгрөг, нийт 300.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой гэж үзлээ.

Бусад орлого /Дуудлага худалдааны орлого/: Орон нутгийн өмчийн дуудлага худалдааны орлогын 2023, 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөө, 10 сарын 31-ний байдлаарх гүйцэтгэлийг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График 9. Дуудлага худалдааны орлогын судалгаа



ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дуудлага худалдааны орлого 2023 онд 6.4 сая төгрөгөөр, 2024 онд 350.0 сая төгрөгөөр давж байсан бол 2025 оны 10 сарын 31-ний байдлаарх 31.0 сая төгрөгөөр давсан байна. Сүүлийн 3 жилийг харахад дуудлага худалдааны орлого давсан үзүүлэлттэй байна.

Төрийн аудитын газраас “Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар сумдад ашиглалтгүй болон илүүдэлтэй хөрөнгийн судалгааг гаргаж, дуудлага худалдаагаар худалдан борлуулж, төсвийн орлогыг нэмэгдүүлэхээр ТЕЗ-д зөвлөмж хүргүүлсэн бөгөөд судалгаагаар авто тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, тоног төхөөрөмж дансны 75 нэр төрлийн илүүдэлтэй болон ашиглалтгүй хөрөнгө байна.

Авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг дансны үнийн 20 хувиар, барилга байгууламжийг газрын үнийг оруулан тооцоолоход нийт 380.5 сая төгрөг төвлөрөх боломжтой байна. Мөн барилга, байгууламжийг дуудлага худалдаагаар борлуулахдаа мэргэжлийн үнэлгээчнээр үнэлүүлж, худалдах доод үнийг дээрх тооцоолсон дүнгээс өсгөх боломжтой юм. Энэхүү тооцоолол нь зөвхөн ТЕЗ-ийн харьяа 64 байгууллагын хувьд хийгдсэн бөгөөд бусад төрийн байгууллагуудаас мөн дуудлага худалдааны орлого орох боломжтой. Иймд дуудлага худалдааны орлогыг тооцоолсон дүнгийн 52.5 хувиар буюу 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна гэж үзлээ.

Хүснэгт №7 Төсвийн орлого нэмэгдүүлэх саналын нэгтгэл

ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛЫН НЭГТГЭЛ

д/д	Татварын нэр төрөл	Нэмэгдүүлэх санал (сая төгрөг)
1	Малын тоо толгойн албан татвар	678.0
2	Галт зэвсгийн албан татвар	8.1
3	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	32.0
4	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	841.6
5	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	134.3
6	Газрын төлбөр	125.0
7	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	125.0
8	Улсын тэмдэгтийн хураамж	34.0
9	Хүү, торгуулийн орлого	300.0
10	Бусад орлого /дуудлага худалдааны орлого/	200.0
ДҮН		2,478.0

БҮЛЭГ 2. ЗАВХАН АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД УРСГАЛ ЗАРДЛЫГ 1,786.6 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ, ТӨСВИЙН ҮР АШГИЙГ 1,328.0 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

2.1. Орон нутгийн төсвийн урсгал зардлыг 1,786.6 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.

2.1.1. Орон нутгийн 2026 оны төсвийн зарлагыг төлөвлөхдөө татварын орлого нэр төрлөөр бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлийг тооцохгүйгээр Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан суурь зарлагаас хөрөнгийн зардлыг 2,157.6 сая төгрөгөөр, аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний зардлыг 2,037.9 сая төгрөгөөр, нэмэгдүүлж төлөвлөсөн нь төсвийн үр ашгийг бууруулж батлах эрсдэлийг дагуулж байна.

Аймгийн 2026 оны төсвийн суурь зарлага өмнөх оноос 178.2 сая төгрөгөөр буюу 0.25 хувиар өссөн байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн зарлагыг Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан дүнгээс 4,195.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 71,492.8 сая төгрөгөөр батлуулахаар төлөвлөжээ. Үүнээс урсгал зардлыг 2,037.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 61,964.8 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 2,157.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 9,561.4 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4-д “жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх”, 31 дүгээр зүйлийн 31.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна”, 31.1.3-д “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Хүснэгт №8 Орон нутгийн 2026 оны төсвийн зардал /сая.төгрөг/

Үзүүлэлт	УИХ-аас баталсан	2026 оны төсвийн төсөл	Зөрүү
Урсгал зардал	59,926.9	61,964.8	2,037.9
Хөрөнгийн зардал	7,370.4	9,561.4	2,157.6
Нийт зардал	67,297.3	71,492.8	4,195.5

Эх сурвалж: Завхан аймгийн 2026 оны төсвийн төсөл

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд төлөвлөсөн урсгал зардалд дүн шинжилгээ хийхэд урсгал зардлыг 1,325.3 сая төгрөгөөр бууруулж, аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгасан 43 арга хэмжээг 2,755.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, мөн цэвэрлэх байгууламжийн байр ашиглалтын зардалд 300.0 сая төгрөг, дэд камерын төвийн үйл ажиллагааны зардалд 82.2 сая төгрөг, цагдаагийн нэг цэгийн үйлчилгээний зардалд 50.0 сая төгрөг, СӨХ-ийн үйл ажиллагааг дэмжихэд 60.0 сая төгрөг, боомтын үйл ажиллагааг дэмжихэд 96.0 сая төгрөг, "Очир-Илч" ОНӨААН-ийн үйл ажиллагааг дэмжихэд 20.0 сая төгрөг, нийт 608.2 сая төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг үйлчилгээний зардалд нэмж төлөвлөсөн байна.

Нэмэгдүүлж төлөвлөсөн 4,195.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрээс 2,500.0 сая төгрөгийг “2026 онд багш, эмч нарын цалин нэмэгдсэнээр

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого нэмэгдэнэ” гэж тооцоолсон байна. Гэвч “багш, эмч нарын цалинг хэдэн хувиар хэзээ нэмэгдүүлэх нь тодорхойгүй, одоог хүртэл шийдвэр гараагүй, мөн 2025 онд төрийн албан хаагчдын орон тоог 9 хувь бууруулсан зэргийг харгалзан, Төрийн аудитын газраас цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 841.6 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна” гэж дүгнэсэн бөгөөд тус орлогыг хийсвэрээр тооцоолж байна.

Харин 1,695.5 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч аймгийн Татварын газраас ирүүлсэн мэдээгээр 2025 оны татварын орлого хүлээгдэж буй гүйцэтгэлээр 417.7 сая төгрөгөөр давж биелэхээр тооцоолсон бөгөөд 2025 оны төсвийн жил дуусаагүй тул урьд оны үлдэгдлийг нотлох боломжгүй байна. Сангийн яамнаас орон нутгийн 2026 оны суурь орлогыг 2,417.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бөгөөд татварын орлогын эх үүсвэр нэмэгдэх боломжийг бүрэн судалж, татварын орлого нэр төрлөөр бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлийг тооцож, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 1,679.0 сая төгрөгийн 20 арга хэмжээний зардлыг бууруулж батлуулах шаардлагатай байна.

Хүснэгт № 9 Аймгийн Засаг дарга дансанд зориулалт бусаар төлөвлөсөн арга хэмжээний жагсаалт

№	Арга хэмжээний нэр	Мөнгөн дүн /сая.төгрөг/	Тайлбар
1	Эмнэлгийн болон театрын урд хэсэгт газар чөлөөлсөн иргэдэд нөхөн олговор олгох	242.0	ТЕЗ-ийн чиг үүрэгт хамаарахгүй
2	Тосонцэнгэл сумын соёлын өвийг түгээх контент бэлтгэх	19.9	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
3	Баянтэс суманд бэлчээр хамгаалах	30.0	Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх
4	Элсэлтийн ерөнхий шалгалтад элсэгчдэд боловсролын зөвлөх үйлчилгээ авах	50.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
5	Олимпиад, элсэлтийн шалгалтад эхний байр эзэлсэн багш, суралцагчдыг дэмжих	80.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
6	Амжилт гаргасан оюутанд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох	50.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
7	Бүс, улс, ОУ-ын тэмцээнд оролцож амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг шагнаж урамшуулна.	50.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
8	“Спортын наадам”-ыг 24 сумын хэмжээнд зохион байгуулах	70.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
9	Хүн амын хөгжил, оролцоог дэмжих, хүний эрхийг хангах чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах	60.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
10	Иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулж гэр авах	60.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
11	Уст цэг тогтоох хайгуул судалгаа хийх	9.0	БХНСАХЗ-аас санхүүжүүлэх
12	"Баруун бүсийн аварга шалгаруулах тогооч"-дын уралдаан зохион байгуулах.	20.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
13	"Залуучуудын чуулга уулзалт, Соёлын фестиваль"-ийг зохион байгуулах	200.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

14	Аялал жуулчлалын "Ай Ти Эм" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, "Улаанбаатар тревел экспо"-д аялал, жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдийг оролцуулах	10.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
15	Гадаад улс орнуудтай хийх хамтын ажиллагаа, түншлэлийг нэмэгдүүлж, олон талт арга хэмжээг зохион байгуулах	50.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
16	"Баруун бүсийн Их Хурд" зохион байгуулах	400.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
17	Тусгай объектын усан хангамж, хамгаалалтын хашаа барих	97.1	Хөрөнгө оруулалтын зардлаас санхүүжүүлэх
18	Хугацаат цэргийн алба хаагчдын албаны үйл ажиллагаатай танилцах, тэдний ар гэрт дэмжлэг үзүүлэх	25.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
19	СӨХ-ийн үйл ажиллагааг дэмжих	60.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
20	Боомтын үйл ажиллагааг дэмжих	96.0	Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн
Дүн		1,679.0	

Төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үйл ажиллагааг Монгол Улсын Төсвийн тухай хууль, холбогдох эрх зүйн актууд, төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжид нийцүүлэн үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөхөөр зохицуулагдсан байдаг.

Хүснэгт № 10 Орон нутгийн 2026 оны төсвийн зардлын ангилал /сая.төгрөг/

Зардлын ангилал	2025 оны тодотгол	Сангийн яамны хянасан	2026 оны төсвийн төсөл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,204.4	67,297.3	71,492.8	4,195.5
УРСГАЛ ЗАРДАЛ	60,562.8	59,926.9	61,964.8	2,037.9
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,404.5	57,192.8	59,113.6	1,920.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	25,592.7	26,029.4	24,891.5	-1,137.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,202.8	3,256.5	3,115.1	-141.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,692.0	21,851.4	20,223.7	-1,627.7
Хангамж, бараа материалын зардал	1,006.9	669.6	1,006.9	337.3
Нормативд зардал	94.0	217.1	94.0	-123.1
Эд хогшил, урсгал засварын зардал	635.1	569.5	678.0	108.5
Томилолтын зардал	329.6	236.3	329.6	93.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,909.8	2,346.9	6,492.3	4,145.4
Бараа үйлчилгээний бусад зардал	1,941.8	2,016.2	2,282.5	266.4
Бараа үйлчилгээний бусад зардал	1,860.6	1,736.8	2,201.0	464.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	81.2	140.6	81.6	-59.0
Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	138.8	0.0	-138.8
Гадаадын зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	39.4	0.0	-39.4
ТАТААС	30.0	21.1	21.1	0.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	30.0	21.1	21.1	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,128.3	2,673.6	2,830.1	156.4
Бусад урсгал шилжүүлэг	1,128.3	2,673.6	2,830.1	156.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,641.6	7,370.4	9,528.0	2,157.6

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

Их засвар	2,117.0	2,007.4	2,008.7	1.3
Бусад хөрөнгө	8,524.6	5,363.0	7,519.3	2,156.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	71,204.4	67,297.3	71,492.8	4,195.5
Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,889.1	67,297.3	69,619.8	2,322.5
Орон нутгийн төсвөөс	67,889.1	67,297.3	69,619.8	2,322.5
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	3,315.3	0.0	177.5	177.5
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	156.9	0.0	156.9	156.9
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20.6	0.0	20.6	20.6
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,137.7	0.0	1,695.5	1,695.5

Эх сурвалж: Завхан аймгийн 2026 оны төсвийн төсөл

Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан зарлагын хязгаараас цалин, НДШ-ийн зардлыг 1,279.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,627.7 сая төгрөгөөр, багаж, техник, хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын зардлыг 78.0 сая төгрөгөөр бууруулан, бусад урсгал зардлыг нэмэгдүүлэн төлөвлөжээ. Үүнд:

Бичиг хэргийн зардлыг 51.3 сая төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 369.4 сая төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 33.6 сая төгрөгөөр, урсгал засварын зардлыг 186.5 сая төгрөгөөр, дотоод албан томилолтын зардлыг 93.3 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардлыг 4,145.4 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 464.2 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 62.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Бараа үйлчилгээний бусад зардал өссөн нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хамааруулж, 24 суманд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуваарилсантай холбоотой байна. Мөн Аймгийн ИТХ-ын төсвийн төсөлд бараа үйлчилгээний бусад зардлыг 107.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Бусад урсгал зардлыг гүйцэтгэлд үндэслэн нэмэгдүүлэн төлөвлөсөн нь үндэслэлтэй байна гэж үзлээ.

Хүснэгт № 11 Орон нутгийн 2026 оны төсвийн зардлыг байгууллагад хуваарилсан байдал

№	Хөтөлбөрийн ангилал	2025 оны тодотгосон төсөв	Сангийн яамнаас хянаж, УИХ-ын баталсан төсөв	2026 оны төсвийн санал /сая.төгрөг/	Зөрүү
1	Аймгийн ИТХ	1,994.7	1,319.0	1,617.9	298.9
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	396.0	571.5	346.0	-225.5
2	Аймгийн ЗДТГ	5,978.8	4,700.5	5,716.0	1,015.5
	Засаг даргын нөөц сан	1,100.0	1,221.8	1,100.0	-121.8
3	Сумын ИТХ	4,008.4	4,986.5	3,530.4	-1,456.1
4	Сумын ЗДТГ	20,398.5	22,969.2	22,006.1	-963.1
5	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	399.3	392.5	392.5	0.0
6	Орон нутгийн өмчийн газар	364.7	282.2	328.2	46.0
7	Худалдан авах ажиллагааны газар	337.2	274.2	289.7	15.5
	БОАЖГазар	2,030.8	2,034.5	2,202.3	167.8
8	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	31.0	120.8	120.8	0.0
9	Ойжуулалт /ойн ангиуд/	430.7	344.9	422.8	77.9
10	Хот тохижилт үйлчилгээний алба	1,791.5	1,247.7	1,807.8	560.0
11	Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв	1,028.7	822.1	1,028.7	206.6

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

12	Эрүүл мэндийн салбарын тогтмол зардал	3,210.6	4,261.5	3,214.6	-1,046.9
13	Боловсролын салбарын тогтмол зардал	11,473.6	11,656.9	11,481.0	-175.9
14	Мэргэжлийн боловсролын тогтмол зардал	867.7	829.3	975.9	146.7
15	Соёл урлагийн тогтмол зардал	2,031.9	2,805.7	2,533.0	-272.6
16	Биеийн тамир, спортын салбарын тогтмол зардал	170.2	170.2	170.2	0.0
17	Засаг дарга данс	4,102.0	2,058.2	5,669.9	3,611.8
18	Мал эмнэлгийн үйлчилгээ	443.8	409.0	443.8	34.7
19	Халамжийн сан	211.7	308.2	211.7	-96.5
20	Ахмадын хороо	188.0	91.8	188.0	96.2
21	Байр ашиглалтын үйлчилгээ /Цэвэрлэх байгууламж/	0.0	0.0	300.0	300.0
22	Байр ашиглалтын үйлчилгээ /Баруун босийн худалдааны төв/	0.0	0.0	20.0	20.0
23	Боомтын үйл ажиллагаа	0.0	0.0	96.0	96.0
24	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /Тель камерсн төв/	0.0	0.0	82.2	82.2
25	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /Цагдаагийн нэг цэгийн үйлчилгээ/	0.0	0.0	50.0	50.0
26	Төрийн бус байгууллагад олгох санхүүжилт /СӨХ/	0.0	0.0	60.0	60.0
27	ОНТ2 /бусад арга хэмжээ/	3,470.2	0.0	2,755.0	2,755.0
28	Нийтийн тээврийн татаас	30.0	21.1	21.1	0.0
29	Замын сан	1,218.0	1,228.1	1,218.0	-10.1
30	Их засвар	2,117.0	2,007.4	2,008.7	1.3
31	Орон нутгийн хөрөнгө оруулалт	7,008.6	4,135.0	6,301.3	2,166.4
	Нийт дүн	71,204.4	67,297.3	71,492.8	4,195.5

Эх сурвалж: Завхан аймгийн 2026 оны төсвийн төсөл

Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан суурь зарлагад Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн хүрээнд “Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн урт хугацаат зээлийн төлбөрийн 39.4 сая төгрөгийг оруулж баталсан бөгөөд Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд зээлийн төлбөрийг төлөвлөөгүй байна. Сангийн яамнаас ирүүлсэн “Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийн 2.7-д заасны дагуу зээлийн төлбөр 39.4 сая төгрөгийг орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тусгах шаардлагатай байна.

Аймгийн ИТХ-ын төсөвт Сангийн яамнаас хянаж, УИХ-аас баталсан суурь зардалд биеийн тамирын уралдаан тэмцээний зардлыг 57.6 сая төгрөгөөр, сургалт, семинарын зардлыг өмнөх оноос 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 27 дугаар зүйлийн 27.1.3-д “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх”, 4.1.7-д “бодитой байх”, 4.2.1-д “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах”, 4.2.3-д “хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх”, 4.2.7-д “аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх”, 15 дугаар зүйлийн 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

байгуулах”, 15.2.7-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасантай нийцэхгүй байгаа тул аймгийн ИТХ-ын төсвөөс бараа үйлчилгээний бусад зардлыг 107.6 сая төгрөгөөр бууруулах шаардлагатай байна.

Дараах хүснэгтээс харахад 2025 оны орон нутгийн төсвийн зарлага хүлээгдэж буй гүйцэтгэлээр 81,469.8 сая төгрөг буюу 84.1 хувийн гүйцэтгэлтэй, 15,364.5 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа ч энэ нь бодитоор хэмнэгдэх эсэхийг тодорхойлох боломжгүй юм.

Хүснэгт № 12 Орон нутгийн төсвийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл /сая.төгрөг/

д/д	Хөтөлбөрийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	6,600.8	5,938.6	662.2
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	30,303.9	27,672.4	2,631.5
3	Мэргэжлийн хяналт	399.3	378.7	20.6
4	Худалдан авах ажиллагаа	337.2	320.9	16.4
5	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	364.7	365.7	-1.0
6	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	30,327.4	24,356.9	5,970.5
7	Мал аж ахуйг хөгжүүлэх	443.8	397.8	45.9
8	Авто замын сан	1,218.0	1,011.7	206.3
9	Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр	30.0	30.0	0.0
10	Ойжуулалт	430.7	412.6	18.1
11	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2,030.8	1,979.4	51.4
12	Хот байгуулалт, тохижилт	1,791.5	1,791.5	0.0
13	Нийгмийн эрүүл мэнд	170.2	156.9	13.3
14	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	3,224.0	2,739.4	484.7
15	Биеийн тамир спорт	1,028.7	931.5	97.2
16	Соёл урлаг	2,044.7	1,416.2	628.4
17	Сургуулийн өмнөх боловсрол	2,402.0	2,074.1	327.9
18	Ерөнхий боловсрол	9,081.6	7,869.0	1,212.6
19	Мэргэжлийн боловсрол	867.7	802.1	65.6
20	Нийгмийн халамж	211.7	211.7	0.0
21	Ахмад настны хөгжил хамгаалал	188.0	188.0	0.0
22	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон албан бус эдийн засагт ажиллагчид	3,337.8	424.8	2,912.9
	ДҮН	96,834.3	81,469.8	15,364.5

Хэмнэлтийн 59.1 хувь буюу 9,089.8 сая төгрөг нь орон нутгийн тусгай сан, орон нутгийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой байна. Харин улсын төсөвт байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 18.8 хувиар, Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны зардал 4.3 хувиар, Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагын үйл ажиллагааны зардал 17.1 хувиар тус тус хэмнэхээр тооцоолсон байна.

2.1.2 Орон нутгийн төсөвт байгууллагуудын орон тоог Сангийн яамнаас хянасан орон тооны хязгаарт багтаан төлөвлөсөн байна.

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын орон тоог хянахад Сангийн яамнаас ирүүлсэн “Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийн дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах байгууллагуудын орон тоонд дүн шинжилгээ хийж, Сангийн яамнаас хянасан орон тооны хязгаарт багтаан төлөвлөсөн байна.

Хүснэгт № 13 Төсвийн урсгал зардал бууруулах санал

ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ БУУРУУЛАХ САНАЛЫН НЭГТГЭЛ

Д/д	Зардлын ангилал	Зардал бууруулах (сая төгрөг)
1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардал /аймгийн Засаг дарга дансанд төлөвлөгдсөн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардал/	1,679.0
2	Бараа үйлчилгээний бусад зардал	107.6
ДҮН		1,786.6

2.2. Орон нутгийн төсвийн үр ашгийг 1,328.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.

2.2.1. Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөс орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүйгээр 1,158.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд их засвар, орон нутгийн авто замын сангийн эх үүсвэр болон байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд зарцуулахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээг авч үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт № 14 Төсөл арга хэмжээ /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний тоо	УИХ-аас баталсан	2026 онд санхүүжих дүн
1	Их засвар	12	2,008.7	2,008.7
2	Авто замын сан	2	1,218.0	1,218.0
3	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал /аймагт/	3	92.0	92.0
4	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал /сумдад/	-	553.8	553.8
Нийт дүн			3,872.5	3,872.5

1. Их засвар: Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд их засварын зардлаар 2,008.7 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт № 15 Их засварын зардлын төлөвлөлт /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал
1	Их-Уул сумын ЭМТ-ийг өргөтгөж шүдний кабинет байгуулах	180.0	ОНТ2
2	Их-Уул сумын Хуягт багийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг засварлах	15.0	ОНТ2
3	Богдын гол багийн байрны засвар хийх	300.0	ОНТ2

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

4	Улиастай сумын Богдын гол багийн Хөгжим бүжгийн 24 айлын орон сууцны гадна фасадыг шинэчилж дулаалах	230.0	ОНТ2
5	Аймгийн Биеийн тамир спортын газрын дасгалын өрөөг засварлаж тоног төхөөрөмж авах	80.0	ОНТ2
6	Аймгийн Биеийн тамир, спортын газрын барилгын цонхыг шинэчилнэ.	124.3	ОНТ2
7	Отгон сумын сургуулийн дотуур байрыг засварлах	350.0	ОНТ2
8	Цэцэн-Уул сумын цаг уурын барилгын дээврийг засварлах	25.0	ОНТ2
9	Нөмрөг сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, засварлах	50.0	ОНТ2
10	Улиастай сумын Богдын гол багийн “Дэвшил” сургуулийн спорт заалны захиргаа аж ахуйн хэсгийн дээврийг засварлах	104.0	ОНТ2
11	Монгол Улсын хөдөлмөрийн баатар Ш.Даваахүүгийн нэрэмжит үндэсний сурын талбайг тохижуулах	100.0	ОНТ2
12	Яруу сумын цэцэрлэгийн барилгад их засвар хийх	450.4	ОНТ2
Нийт дүн		2,008.7	

Дээрх хүснэгтээс харахад: Их засварын зардлаас санхүүжих төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаа бөгөөд орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагад нийцсэн байна гэж үзэхээр байна.

2. Орон нутгийн авто замын сан: Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд автозамын сангийн хөрөнгөөр 1,218.0 сая төгрөгийн 2 ажлыг гүйцэтгэхээр төлөвлөжээ. Үүнд:

Хүснэгт № 16 Орон нутгийн авто замын сангийн төлөвлөлт

№	Төсөл арга хэмжээний нэр	Зураг төсөвтэй эсэх	Төсөвт өртөг /сая төгрөг/	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал
1	Их-Уул сумын Халуун усны рашаан, Тээлийн давааны замыг засварлах, Зөрүүлэгт гүүр барих	Тийм	60.0	ОНЗС
2	Авто замын сангийн хөрөнгөөр цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх	Үгүй	1,158.0	ОНЗС
Нийт			1,218.0	

Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр “цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх” гэх нэршлээр 1,158.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг судлаагүй, төсвийг орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, бодитой төлөвлөөгүй байна.

3. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 553.8 сая төгрөгийг сумдад хуваарилж, аймагт 92.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт № 17 Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөлт

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал
---	--------------------------	---------------------------	------------------------------------

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

1	Усны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, сурталчлан таниулах, сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	12.0	БХНСАХЗ
2	Газрын болон 24 сумын байгаль хамгаалагчдын нийгмийн баталгааг хангаж шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх	19.0	БХНСАХЗ
3	Гадаргын усны тооллого зохион байгуулах	15.0	БХНСАХЗ
4	Байгаль орчны салбарын албан хаагчдыг чадавхжуулах, сэлгэн ажиллуулах, сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах	20.0	БХНСАХЗ
5	Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл дасан зохицох талаар мэдлэг мэдээлэл олгож чадавхжуулах	8.0	БХНСАХЗ
6	Байгаль орчны салбарын хяналт шалгалтыг хийх	18.0	БХНСАХЗ
7	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал /сумдад/	553.8	БХНСАХЗ
Нийт		645.8	

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас сургалт зохион байгуулахаар 20.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.2-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.4-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах”, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.3, 3.4, 3.5, 3.6, 3.7 дахь заалттай нийцэхгүй байна. Иймд Сангийн яамнаас ирүүлсэн “Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг баримтлан, зориулалт бус үйл ажиллагаанд төлөвлөсөн 20.0 сая төгрөгийг журмын дагуу шаардлага хангасан төсөл арга хэмжээнд төлөвлөх шаардлагатай байна.

2.2.2. Их засварын зардлаас хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй 150.0 сая төгрөгийн зориулалт бус 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Орон нутгийн автозамын сангийн хөрөнгөөс хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тодорхойлоогүйгээр 1,158.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь хууль, журамд заасан төлөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

Хүснэгт № 18 Их засварын зардлаас зориулалт бус төлөвлөлт /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Зураг төсөвтэй эсэх	Төсөвт өртөг	Тайлбар
1	Нөмрөг сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, засварлах	ТЭЗҮ-гүй	50.0	Зориулалт бус
2	Монгол Улсын хөдөлмөрийн баатар Ш.Даваахүүгийн нэрэмжит үндэсний сурын талбайг тохижуулах	ТЭЗҮ-гүй	100.0	Зориулалт бус
Нийт дүн			150.0	

Дээрх хүснэгтээс харахад: Их засварын зардлаас хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй 150.0 сая төгрөгийн зориулалт бус 2 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.2-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.4-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах”, 14.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-д “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3-д “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэж заасантай нийцэхгүй байна. Иймд Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн яамнаас ирүүлсэн “Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг баримтлан, их засварын зардлыг тухайн барилга, байгууламжийн насжилтыг уртасгах, барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, их засварын шинжтэй ажлуудыг тусгаж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн автозамын сангийн хөрөнгөөс орон нутгийн бодит хэрэгцээ шаардлагыг судлаагүй, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тодорхойлоогүйгээр 1,158.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь хууль, журамд заасан төлөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

Хүснэгт № 19 Орон нутгийн авто замын сангийн төлөвлөлт

№	Төсөл арга хэмжээний нэр	Зураг төсөвтэй эсэх	Төсөвт өртөг /сая төгрөг/	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал
1	Авто замын сангийн хөрөнгөөр цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх	Үгүй	1,158.0	ОНЗС
Нийт			1,158.0	

Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр “цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх” гэх нэршлээр 1,158.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4-д “өөрийн

эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах”, 22 дугаар зүйлийн 22.6-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үе шат бүрд төсвийн ангиллыг дараах байдлаар хэрэглэнэ”, 22.6.4-д “төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах”, 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэж заасантай нийцэхгүй, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлтийн шаардлага хангахгүй байна. Сангийн хөрөнгийг хэдэн төгрөгөөр, хэдэн төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх нь тодорхойгүй төлөвлөсөн нь хөрөнгө зориулалт бусаар, үр ашиггүй, үрэлгэн зарцуулагдах эрсдэлийг дагуулж байна. Иймд төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөх нь зүйтэй байна.

Аудитаар орон нутгийн төсвийн үр ашгийг дээшлүүлэх дараах боломжууд байна гэж дүгнэлээ. Үүнд:

- Их засварын зардлаас 150.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг зориулалт бус үйл ажиллагаанд төлөвлөснийг бодит хэрэгцээ шаардлагад тулгуурлан тухайн барилга, байгууламжийн насжилтыг уртасгах, их засварын шинжтэй ажлуудад төлөвлөж төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас сургалт зохион байгуулах 20.0 сая төгрөгийг шаардлага хангасан төсөл арга хэмжээнд төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;

- Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөс 1,158.0 сая төгрөгийг төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХУУЛЬ, ЖУРМЫН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ, ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХГҮЙ 9 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД НИЙТ 1,290.5 САЯ ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

3.1. Орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөж, хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй 635.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, хууль, журамд заасан чиг үүрэгт хамаарахгүй 655.5 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

3.1.1. Орон нутгийн хөрөнгө оруулалт болон аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 70 төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн байна.

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

ОНХНС-аас 11,862.2 сая төгрөгийг хуваарилснаас 5,834.5 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 6,027.7 сая төгрөгийг сумдын ОНХС-д олгохоор төлөвлөжээ.

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 6,301.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл арга хэмжээг, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 5,834.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт №20. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ

№	Төсөл арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр	Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн төсөл арга хэмжээний тоо	Төсөл арга хэмжээний тоо	УИХ-аас баталсан дүн	2026 оны төсвийн төсөлд /сая.төгрөг/
1.	Орон нутгийн хөрөнгө оруулалт	34	34	4,145.0	6,301.3
2.	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	36	36	5,834.5	5,834.5
3.	Сумдын Орон нутгийн хөгжлийн сан	-	-	6,027.7	6,027.7
Нийт дүн		70	70	16,007.2	18,163.5

3.1.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хууль, журамд заасан шаардлага хангаагүй 635.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Орон нутгийн 2026 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд хууль, журамд заасан шаардлага хангаагүй 635.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.7-д “бодитой байх”, 4.2.7-д “аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх”, 13 дугаар зүйлийн 13.3-д “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3-д “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэж заасантай нийцэхгүй байна.

Хүснэгт №21. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээний жагсаалт /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зураг төсөвтэй эсэх
1	Улиастай сумын Жинст багийн Дүнзэн байрны айл, өрхүүдийг бохир усны шугам сүлжээнд холбох	120.0	ТЭЗҮ-гүй

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

2	Тэс суманд бетон авто зам хийх /2026 онд 300.0 сая төгрөг, 2027 онд 500.0 сая төгрөг санхүүжнэ/	300.0	Зураг төсөвгүй
3	Улиастай сумын Жинст багийн Маамын Лхагвын байрны гадна талбайд тохижилт хийх	120.0	ТЭЗҮ, тооцоо судалгаагүй
4	Завханмандал сумын Ногоон хэрмийн зурвасын хайсыг шинэчлэх	95.0	ТЭЗҮ, тооцоо судалгаагүй
Нийт дүн		635.0	

Иймд шаардлага хангасан дараагийн төсөл, арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

3.1.3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 80.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг, Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас хууль, журамд нийцээгүй, зориулалт бус 575.5 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын чиг үүрэгт хамаарахгүй, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 2 төсөл, арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

- *"Шашны аялал жуулчлал"-ыг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд контент хийх, Завхан аймгийн танилцуулга хийх 50.0 сая төгрөг;*
- *Отгор нүүдлээр яваа малчдад эрүүл мэнд болон төрийн үйлчилгээ үзүүлэх 30 сая төгрөг;*

Иймд дээрх төсөл арга хэмжээг хууль журамд нийцсэн дараагийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд төлөвлөж, төсвийн үр ашгийг 80.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн 2026 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд хууль, журамд заасан шаардлага хангаагүй, зориулалт бус 575.5 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.4-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах”, 27 дугаар зүйлийн 27.1.3-д “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.7-д “бодитой байх”, 4.1.9-д “хариуцлагатай байх” гэж заасантай нийцэхгүй байна.

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

Хүснэгт № 22. Зориулалт бус төсөл арга хэмжээний төлөвлөлт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөгөөр/
1	Их-Уул сумын Отор нүүдлээр явдаг малчдыг богино долгионы станцаар хангах	19.5
2	Алдархаан суманд төрийн албан хаагчийн байр худалдаж авах	225.0
3	Аймгийн ИТХ-ын ажлын албанд үйлчилгээний автомашин авах	331.0
Нийт дүн		575.5

Иймд дээрх төсөл арга хэмжээнүүдийг хасаж, дахин төлөвлөхгүй байх нь зүйтэй байна.

Хүснэгт № 23 төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх саналын нэгтгэл

ТӨСВИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛЫН НЭГТГЭЛ

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Үр ашиг нэмэгдэх санал (сая төгрөг)	САНАЛ
1	Их засварын зардлаас хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй, зориулалт бус 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	150.0	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
2	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн.	20.0	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
3	Орон нутгийн автозамын сангийн хөрөнгөөс орон нутгийн бодит хэрэгцээ шаардлагыг судлаагүй, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тодорхойлоогүйгээр 1,158.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь хууль, журамд заасан төлөвлөлтийн шаардлага хангахгүй бөгөөд сангийн хөрөнгө зориулалт бусаар, үр ашиггүй, үрэлгэн зарцуулагдах эрсдэлийг дагуулж байна.	1,158.0	Шаардлага хангасан төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;
4	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 2 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	80.0	Журамд нийцсэн дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
5	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй, зориулалт бус 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	575.5	Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжгүй, зориулалт бус төсөл арга хэмжээнүүдийг хасаж, дахин төлөвлөхгүйгээр төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх
6	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хууль журмын шаардлага хангаагүй 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	635.0	Шаардлага хангасан дараагийн төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

ДҮН	2,618.5	
-----	---------	--

АУДИТААР ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 10 НЭР ТӨРӨЛД 2,478.0 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОН УРСГАЛ ЗАРДЛЫГ 1,786.6 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ, ТӨСВИЙН ҮР АШГИЙГ 2,618.5 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛЫГ ХҮРГҮҮЛЛЭЭ.

1.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, дүн шинжилгээнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогыг 10 нэр төрөлд 2,478.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
2. Орон нутгийн 2026 оны төсвийн урсгал зардлыг 107.6 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.
3. Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд төлөвлөсөн урсгал зардалд дүн шинжилгээ хийхэд урсгал зардлыг 1,325.3 сая төгрөгөөр бууруулж, аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгасан 43 арга хэмжээг 2,755.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр аймгийн Засаг дарга дансанд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг үйлчилгээний зардалд нэмж төлөвлөсөн бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 1,679.0 сая төгрөгийн 20 арга хэмжээний зардлыг бууруулж батлах шаардлагатай байна.
4. Орон нутгийн автозамын сангийн хөрөнгөөс орон нутгийн бодит хэрэгцээ шаардлагыг судлаагүй, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тодорхойлоогүйгээр 1,158.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь хууль, журамд заасан төлөвлөлтийн шаардлага хангахгүй бөгөөд сангийн хөрөнгө зориулалт бусаар, үр ашиггүй, үрэлгэн зарцуулагдах эрсдэлийг дагуулж байна.
5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төсөвгүй 635.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
6. Орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, их засвар болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хууль, журамд нийцээгүй, чиг үүрэгт хамаарахгүй 7 төсөл арга хэмжээнд 825.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

ЗӨВЛӨМЖ

“Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитын дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Ш.МЯНГАНБАЯР-Т

1. Орон нутгийн 2026 оны төсвийн урсгал зардалд төлөвлөсөн Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 1,679.0 сая төгрөгийн 20 арга хэмжээний зардал болон АИТХ-ын сургалт семинар, биеийн тамирын уралдаан тэмцээний зардалд төлөвлөсөн 107.6 сая төгрөгийн зардлыг бууруулж, төсвийг үр ашигтай байхаар батлах;

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.ӨНӨРБАЯР-Т

1. Орон нутгийн төсвийн орлогыг аудитын тооцоолсноор 2,478.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөх;
2. Орон нутгийн 2026 оны төсвийн урсгал зардлыг 107.6 сая төгрөгөөр, аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгасан Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 20 арга хэмжээний зардлыг 1,679.0 сая төгрөгөөр тус тус бууруулж төлөвлөн, батлуулах;
3. Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөс 1,158.0 сая төгрөгийг шаардлага хангасан төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөх;
4. Хууль, журамд заасан шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн 635.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг дараагийн шаардлага хангасан төсөл арга хэмжээнд төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;
5. Орон нутгийн хөрөнгө оруулалтаас хууль, журамд нийцээгүй, зориулалт бус арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн 575.5 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг хасаж, дахин төлөвлөхгүй байх;
6. Хууль, журамд нийцээгүй, чиг үүрэгт хамаарахгүй 250.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг шаардлага хангасан дараагийн төсөл, арга хэмжээнд зориулалтын дагуу төлөвлөж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх;

Аудитаар өгсөн зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу төлөвлөгөө гарган ирүүлж, хэрэгжилтийг 2026 оны 01 дүгээр сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

**АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсээс аудитын тайлангийн төсөлд 2,837.0 сая төгрөгийн зөрчлийг хасуулахаар ирүүлсэн 2 саналыг аудитын баг хэлэлцэж, дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, бусад холбогдох журмыг зөрчсөн тул саналыг хүлээж авах боломжгүй бөгөөд 2,837.0 сая төгрөгийн зөрчлийг хэвээр үлдээхээр шийдвэрлэлээ.